



СЭЛЭНГЭ АЙМАГ
ЗҮҮНБҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 23 өдөр

Дугаар

А/ЗБ

Жаргалант

Вакцинжуулалтын ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.3-ын "а" заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зүүнбүрэн сумын Мангирт 3 дугаар багийн Орос даваа, Ар урт гэх газарт олон улсын хорио цээрт малын гоц халдварт А01 шүлхий өвчин батлагдан голомт үүссэнтэй холбогдуулан сумын хэмжээний мал сүрэг, тэжээвэр амьтанд вакцинжуулалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Засаг даргын Тамгын газрын дарга

Д.Гантулга

Нарийн бичгийн дарга:

Мал эмнэлгийн тасгийн дарга

Г.Отгонжаргал

Гишүүдэд:

Мал аж ахуй үйлдвэрлэлийн технологи,
үржил бүртгэл хариуцсан мэргэжилтэн
Тархвар зүйч

Б.Мөнхтөр
О.Өлзийбүрэн

Жаргалант багийн Засаг дарга

Ч.Уранчимэг

Бэлчир багийн Засаг дарга

С.Бат-Эрдэнэ

Мангирт багийн Засаг даргын

үүргийг түр орлон гүйцэтгэгч

Г.Батчимэг

"Оюутсүрэг" МЭҮН-н захирал

Д.Хишигсүрэн

"Энхбүрэнсүрэг" МЭҮН-н захирал

Ц.Сэлэнгэ

2. Вакцинжуулалтын хугацаанд иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлаж голомтыг болон эрсдэлтэй, хамгаалалтын бүсийн малчин мал бүхий иргэдийн дотуур байрны хүүхдүүдийг явуулахгүй байхыг Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Ц.Уранбодол)-д даалгасугай.

3. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад мал сүрэг болон тэжээвэр амьтдаа бүрэн хамруулах ухуулга сурталчилгааг багийн хэмжээнд зохион байгуулж ажиллахыг Багийн Засаг дарга нарт даалгасугай.

D;(Zasag darga)Zahiramj

00000000

4. Сумын хэмжээний мал сүрэг, тэжээвэр амьтанд хийх вакцинжуулалтыг
товлосон хугацаанд гүйцэтгэж хэрэгжүүлсэн ажлын тайланг холбогдох дээд шатны
байгууллагад хүргүүлж ажиллахыг ажлын хэсэгт даалгасугай.

ДАРГА



Э.САРАНБААТАР